



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

/2023 оны 12 сарын 31-ний байдлаар/

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу 2022 оны 12 дугаар сард нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй арилжин нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн билээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар үнэт цаасны танилцуулгад тодорхой тусгасан бөгөөд компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн болно.

№	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	
1	Арилжааны систем сайжруулалт	63.7%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.7%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.1%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.5%
Нийт		100.0%

Компани 2023 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 6.1 тэрбум төгрөгийн зарцуулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд үүнд:

- Мэдээлэл технологийн шинэчлэл сайжруулалт болон Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгоход нийт 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн болно. Үүнээс мэдээлэл технологийн шинэчлэл сайжруулалтад зориулах 3.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтад арилжааны системийн түүхий эд болон деривативын арилжааны модуль, IPO болон Comex системийн шинэчлэл, МХБ-ийн дотоод үйл ажиллагааны автоматжуулалт, серверийн өрөөний стандартжуулалт, дагалдах өгөгдлийн сангийн лицензүүд багтсан;

- Арилжааны дэд бүтэц болох МIТ системийн жилийн үйлчилгээний зардалд ЛХБ групптэй байгуулсан “Лиценз, засвар үйлчилгээний гэрээ”-ний дагуу 2023 онд 1.1 тэрбум төгрөг төлөхөөр тусгагдсан болно.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар танилцуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	Хэрэгжилт			
1	Арилжааны систем сайжруулалт	7,590,339.31	63.70%	1,264,996.97	10.6%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	1,274,986.35	10.70%	65,896.31	0.6%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	726,861.38	6.10%	76,801.45	0.6%

4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	2,323,573.26	19.50%	79,417.25	0.7%
Нийт		11,915,760.30	100%	1,487,111.98	12%

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдаж авах ажиллагаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон компанийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зориулалтын дагуу үе шаттайгаар хэрэгжиж байгаа болно.

Тайлан бэлтгэсэн: Захиргаа, санхүүгийн газар